

# МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН САРЫН МЭДЭЭ

2025 оны 08 дугаар сар

АГУУЛГА:

1. ДНБ
2. Гадаад худалдаа
3. Түүхий эдийн үнийн хандлага
4. УУ-н бүтээгдэхүүний биржийн арилжаа
5. Төлбөрийн тэнцэл, валютын нөөц
6. Инфляц
7. Төсөв
8. Мөнгө, санхүү
9. Хөдөлмөр
10. Аж ахуйн нэгж
11. Гадаад эдийн засаг – ОХУ, БНХАУ



ЭДИЙН ЗАСАГ 2024 ОНД

ДНБ-ий өсөлт

(2024 он)

5.1 хувь

Гадаад валютын нөөц

(2024 оны эцэс)

5.5 тэрбум \$

Инфляц

(2024 оны 12 дугаар сар)

9.0 хувь

Төсвийн тэнц. тэнцэл

(2024 оны эцэс)

-776 тэрбум ₮

Экспорт

(2024 оны эцэс)

15.8 тэрбум \$

Импорт

(2024 оны эцэс)

11.6 тэрбум \$

ГШХО

(2024 он)

4.2 тэрбум \$

Зээлийн хүү

(2024 оны 12 дугаар сар)

16.9 хувь

Ажилчдын тоо

(2024 он)

1.36 сая

\*2024 оны байдлаар ажиллах хүчний оролцооны түвшин 61.3 хувь байна.

Бодит цалингийн өсөлт

(2024 он)

2.9 хувь

\*ХҮИ 2020=100

Үйл ажиллагаа явуулж буй ААНБ

(2024 оны эцэс)

108.4 мянга

\*Худалдаа, үйлчилгээ, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарууд давамгайлж байна.

Өрхийн бодит орлогын өсөлт

(2024 он)

9.0 хувь

ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД – 2025.08

ДНБ-ий өсөлт

(2025 оны 2 дугаар улирал)

5.6 хувь

Гадаад валютын нөөц

(2025 оны 8 дугаар сар)

5,683 сая \$

Инфляц

(2025 оны 8 дугаар сар)

8.8 хувь

Төсвийн тэнц. тэнцэл

(2025 оны 8 дугаар сар)

-1,248 тэрбум ₮

Экспорт

(2025 оны 8 дугаар сар)

9,158 сая \$

Импорт

(2025 оны 8 дугаар сар)

7,477 сая \$

ГШХО

(2025 оны 2 дугаар улирал)

695 сая \$

Зээлийн хүү

(2025 оны 8 дугаар сар)

17.0 хувь

Ажилчдын тоо

(2025 оны 2 дугаар улирал)

1.39 сая

\*11 улирлын байдлаар ажиллах хүчний оралцооны түвшин 61.9 хувь байна.

Бодит цалингийн өсөлт

(2025 оны 2 дугаар улирал)

8.4 хувь

\*ХҮИ 2020=100

Үйл ажиллагаа явуулж буй ААНБ

(2025 оны 2 дугаар улирал)

111.7 мянга

\*Худалдаа, үйлчилгээ, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарууд давамгайлж байна.

Өрхийн бодит орлогын өсөлт

(2025 оны 2 дугаар улирал)

8.0 хувь


# 2025 оны 2 дугаар улирал



Эдийн засгийн өсөлт 2025 оны эхний хагас жилд 5.6 хувь болж сэргэлээ. Хөдөө аж ахуй, боловсруулах, эрчим хүч, барилгын салбар өсөлтийг дэмжсэн бол худалдаа, тээврийн салбар агшиж өсөлтийг сааруулав.

## ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Бодит ДНБ 2025 оны эхний хагас жилд **5.6 хувиар өслөө**.
- Анхдагч салбар: Хөдөө аж ахуйн салбар 35.6 хувиар тэлж, өсөлтийн 3.6 нэгж хувийг, уул уурхайн салбар 1.1 хувиар тэлж, өсөлтийн 0.1 нэгж хувийг бүрдүүлэв.
- Хөөрөгдөх салбар /боловсруулах, барилга, цахилгаан, усан хангамж/-ын үйлдвэрлэл 9.6 хувиар өсөж өсөлтийн 1.0 нэгж хувийг бүрдүүлэв.
- Үйлчилгээний салбар /үйлчилгээний бусад салбар өссөн, тээвэр, худалдааны салбар агшсан/ 1.5 хувиар өсөж, өсөлтийн 0.7 хувийг бүрдүүллээ.
- Бүтээгдэхүүний цэвэр татвар 0.9 хувиар өсөж, өсөлтийг 0.2 нэгж хувиар дэмжив.

## ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

(салбараар)


| ДНБ                | 2024.11 | 2025.11 |
|--------------------|---------|---------|
|                    | 5.7     | 5.6     |
| Хөдөө аж ахуй      | -26.7   | 35.6    |
| Уул уурхай         | 15.3    | 1.1     |
| Боловсруулах       | 4.1     | 5.8     |
| Цахилгаан, ус      | 5.3     | 8.4     |
| Барилга            | 22.0    | 25.2    |
| Худалдаа           | 10.9    | -5.7    |
| Тээвэр             | 20.1    | -12.5   |
| Мэдээлэл, холбоо   | 19.0    | 16.6    |
| Үйлчилгээний бусад | 7.7     | 4.5     |
| Цэвэр татвар       | 13.8    | 0.9     |

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Эдийн засгийн өсөлтөд хөдөө аж ахуйн салбарын сэргэлт болон үйлчилгээний бусад салбарын өсөлт голлон нөлөөлөв.
- Уул уурхай, боловсруулах, барилга цахилгаан, усан хангамжийн салбарын үйлдвэрлэл нэмэгдэж, өсөлтөд эергээр нөлөөлж байна.
- Харин нүүрс тэжээрлэгч аж ахуйн нэгжүүдийн орлого буурснаар тээврийн салбар агшив.
- Мөн хүнсний бүс бүтээгдэхүүний худалдаа буурч, худалдааны борлуулалт агшсан байна.

УУЛ УУРХАЙ

(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Уул уурхайн салбар 2025 оны эхний улиралд 1.1 хувиар өснөө.
- Үүнд эзсийн баяжмал үйлдвэрлэл 970 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 32 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.
- Харин нүүрс, алт, газрын тос, төмрийн хүдэр зэргэ бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2025 оны эхний хагас жилд буурсан байна.
- Тухайлбал, нүүрс олборлолт 44 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 11 хувиар, төмрийн хүдэр 4.8 хувиар, газрын тос олборлолт 11 хувиар, алт олборлолт 16 хувиар тус тус буурав.

## ХӨДӨӨ АЖ АХУЙ

(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- ХАА-н салбар 2025 оны эхний хагас жилд 35.6 хувиар өслөө.
- Цаг агаарын нөхцөл байдал хэвийн байж, бойжсон төлийн тоо толгой 20.8 саяд хүрч (төл бойжилт 98.5 хувь) өмнөх оны мөн үеэс 5.4 сая толгой малаар нэмэгдэн, том малын зүй бус хорогдол 189 мянга болж, өмнөх оны мөн үеэс 7.9 сая толгой малаар буурсны голлох нөлөөгөөр сүүлийн хоёр жил дараалан буурсан хөдөө аж ахуйн салбар сэргэв.

1.2 ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖЕРИЙН ИНДЕКС (PMI)2025 оны 2 дугаар улирал



Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн эдийн засгийн хүлээлтийг илэрхийлдэг худалдан авалтын менежерийн индекс (PMI) 2025 оны 2 дугаар улиралд 50.2 хувь болж, эргэн эерэг төлөвт шилжлээ.

PMI  
(50=өөрчлөлтгүй)

| Year | PMI  |
|------|------|
| 2021 | 48.3 |
| 2022 | 50.2 |
| 2023 | 50.2 |
| 2024 | 50.2 |
| 2025 | 50.2 |

Эх сурвалж: Монголбанк

PMI, гол салбараар  
(50=өөрчлөлтгүй)

| Year | Аж үйлдвэр | Барилга | Дотоод худалдаа | Үйлчилгээ |
|------|------------|---------|-----------------|-----------|
| 2021 | 41.2       | 41.2    | 41.2            | 41.2      |
| 2022 | 41.2       | 41.2    | 41.2            | 41.2      |
| 2023 | 41.2       | 41.2    | 41.2            | 41.2      |
| 2024 | 41.2       | 41.2    | 41.2            | 41.2      |
| 2025 | 56.7       | 44.8    | 42.5            | 41.2      |

Эх сурвалж: Монголбанк

PMI, аж ахуйн нэгжийн төрлөөр  
(50=өөрчлөлтгүй)

| Year | Том  | Дунд | Жижиг |
|------|------|------|-------|
| 2021 | 41.6 | 41.6 | 41.6  |
| 2022 | 41.6 | 41.6 | 41.6  |
| 2023 | 41.6 | 41.6 | 41.6  |
| 2024 | 41.6 | 41.6 | 41.6  |
| 2025 | 52.4 | 46.6 | 41.6  |

Эх сурвалж: Монголбанк

PMI, үзүүлэлтүүдээр  
(50=өөрчлөлтгүй)

| Year | Шинэ захиалга | Үйлдвэрлэл | Ажил эрхлэлт | Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа | Түүхий эд материалын нөөц |
|------|---------------|------------|--------------|-----------------------------------|---------------------------|
| 2022 | 41.6          | 41.6       | 41.6         | 41.6                              | 41.6                      |
| 2023 | 41.6          | 41.6       | 41.6         | 41.6                              | 41.6                      |
| 2024 | 41.6          | 41.6       | 41.6         | 41.6                              | 41.6                      |
| 2025 | 60.0          | 52.4       | 46.6         | 41.6                              | 41.6                      |

Эх сурвалж: Монголбанк

■ Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн эдийн засгийн хүлээлтийг хэмждэг Худалдан авалтын менежерийн индекс (PMI) 2025 оны 2 дугаар улиралд 50.2 хувь болж, өмнөх улирлаас 1.9 нэгж хувиар сайжирсан бол өмнөх оны мөн үеэс 4.1 нэгж хувиар доогуур гарлаа.

■ Барилгын салбарын PMI өмнөх улирлаас 2.6 хувиар сайжирсан ч 41.2 хувь болж, тогтмол сөрөг хүлээлттэй хэвээр байна.

■ Аж үйлдвэрийн салбарын бизнес эрхлэгчид эерэг хүлээлтээ хадгалж, өмнөх улирлаас 5.9 нэгж хувиар сайжирчээ.

■ Харин үйлчилгээний салбар 2 улирал дараалан, худалдааны салбар 4 улирал дараалан сөрөг хүлээлттэй байна.

■ 200-аас дээш ажиллагчтай том аж ахуйн нэгжүүдийн PMI индекс 52.4 хувьтай, эерэг төлөвтэй байгаа хэдий ч 3 улирал дараалан буурсан үзүүлэлттэй байна.

■ Харин 50-199 ажиллагчтай дунд хэмжээний аж ахуйн нэгжүүдийн PMI өмнөх улирлаас 2.0 нэгжээр нэмэгдсэн ч 46.6 хувьтай, сөрөг төлөвт байна.

■ 49 хүртэлх ажиллагчтай жижиг бизнесүүдийн PMI 41.6 хувь болж, сүүлийн 5 жилийн турш сөрөг хүлээлттэй байна.


■ Түүхий эд, материалын нөөцийн үзүүлэлт өмнөх жилүүдээс илүү эерэг байгаа бол шинэ захиалгын тоо, үйлдвэрлэлийн хэмжээ зэрэг гол бизнесийн үзүүлэлтүүд буурна гэсэн хүлээлттэй байна.



Эрэлт талаас эдийн засгийн өсөлтийг өрхийн хэрэглээ болон нийт хөрөнгө оруулалт голлон дэмжлээ.

ДНБ-ий өсөлт


(жилийн өсөлтийн хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ТӨРИЙН БОЛОН ӨРХИЙН  
ХЭРЭГЛЭЭНИЙ ӨСӨЛТ

(жилийн өсөлтийн хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ХӨРӨНГИЙН ХУРИМТЛАЛЫН  
ӨСӨЛТ


(жилийн өсөлтийн хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ЭКСПОРТ, ИМПОРТЫН ӨСӨЛТ

(жилийн өсөлтийн хувь)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


- Эдийн засгийн өсөлтийг дотоод эрэлт голлон дэмжив. Нийт өсөлтийн 7.8 нэгж хувийг өрхийн хэрэглээ, 6.5 нэгж хувийг үндсэн хөрөнгийн хуримтлал бүрдүүлсэн байна.
- Харин цэвэр экспорт өсөлтийг 4.7 нэгж хувиар бууруулав. Үүнд 3.0 нэгж хувийг экспортын бууралт, 1.7 нэгж хувийг импортын өсөлт бүрдүүлсэн байна.
- Төрийн хэрэглээ бодит дүнгээр өмнөх оны мөн үеэс 3.7 хувиар буурсан бол өрхийн хэрэглээ 9.9 хувиар өсжээ.
- Үндсэн хөрөнгийн хуримтлал 18.6 хувиар өсөхөд биологийн өсөж үрждэг хөрөнгийн нөөц өмнөх оны мөн үеэс нэрлэсэн дүнгээр 1.1 их наяд төгрөгөөр, орон сууцны барилга бодитоор 20.5 хувиар, бусад барилга байгууламж 19.7 хувиар тус тус нэмэгдсэн нь нөлөөллөө.
- Бараа, үйлчилгээний экспорт өмнөх оноос 4.5 хувиар буурсан бол бараа, үйлчилгээний импортын өсөлт саарч 1.5 хувь болсон нь цэвэр экспортод эерэг нөлөө үзүүлж байна.



Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2025 оны эхний 8 сард 5.8 хувиар буурлаа. Уул уурхайн салбарт нүүрс, алт, газрын тос олборлолтын биет хэмжээ өмнөх оны мөн үеэс буурсан нь голлон нөлөөлөв.



- Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 2025 оны эхний 8 сард 27.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 5.8 хувиар буурлаа.
- Зэсийн баяжмалын үйлдвэрлэл өссөн ч нүүрс болон газрын тосны үйлдвэрлэл буурснаар уул уурхайн салбарын үйлдвэрлэл нэрлэсэн дүнгээр 10.7 хувиар буурлаа.
- Боловсруулах салбарын нийт үйлдвэрлэл (нэрлэсэн дүнгээр) 2025 оны эхний 8 сард 7 хувиар өсөхөд хүнсний бүтээгдэхүүн, мах, төмөрлөг бус эрдэс бодисын үйлдвэрлэл нэмэгдсэн нь нөлөөлөв.



- Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлийн 70 орчим хувийг\* уул уурхайн салбар, түүн дотор 43 хувийг нь нүүрсний олборлолт эзэлдэг.
- Нүүрсний олборлолт 2025 оны эхний 8 сард 59.7 сая тонн болж, өмнөх оны мөн үеэс 9.5 хувиар буурлаа. Харин тухайн сараар буюу 2025 оны 8 сарын байдлаар нүүрс олборлолт өмнөх оны мөн үеэс 5.3 хувиар буурсан байна.

\*2024 оны байдлаар


### УУЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТ

(голлох бүтээгдэхүүнээр)

|                |                        | өмнөх оноос өөрчлөлт: |
|----------------|------------------------|-----------------------|
| Зэсийн баяжмал | <b>1,344 мян.тонн</b>  | 38.7%                 |
| Газрын тос     | <b>2.5 сая баррель</b> | -10.9%                |
| Алт            | <b>7.2 тонн</b>        | -12.1%                |
| Төмрийн хүдэр  | <b>7.9 сая.тонн</b>    | 25.1%                 |

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


- Оюутолгойн зэсийн баяжмалын үйлдвэрлэл нэмэгдсэнээр 2025 оны эхний 8 сард нийт зэсийн баяжмалын үйлдвэрлэл 38.7 хувиар өсөж 1,344 мянган тоннд хүрэв.
- Төмрийн хүдэр, төмрийн хүдрийн баяжмал үйлдвэрлэл 7.9 сая тоннд хүрч, 25.1 хувиар өссөн байна.
- Харин алт болон газрын тос олборлолт өмнөх оны мөн үеийн үйлдвэрлэлийн түвшнээс доогуур хэвээр байна.




- Үйлдвэрлэгчийн үнийн индекс 2025 оны 8 дугаар сард өмнөх оны мөн үеэс 2.8 хувиар буурсан байна.
- Үнэ өссөн:
- Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл 8.8 хувиар;
  - Ундаа үйлдвэрлэл 17.8 хувиар;
  - Тавилгаас бусад мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл 6.3 хувиар;
  - Цахилгаан, хий, уур, агааржуулалт 38.2 хувиар тус тус өссөн;
- Үнэ буурсан:
- Нүүрс олборлолт 37.7 хувиар;
  - Газрын тос олборлолт 14.3 хувиар
  - Металл үйлдвэрлэл 0.2 хувиар тус тус буурсан байна.




Боловсруулах салбарын нийт үйлдвэрлэл 2025 оны эхний 8 сард бодит дүнгээр 1.0 хувиар өсөв. Үүнд, төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн үйлдвэрлэл, металл үйлдвэрлэлийн өсөлт голлон нөлөөллөө.




- Боловсруулсан малын мах 2025 оны эхний 8 сард 22.5 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 11.0 хувиар буурлаа.
- Боловсруулсан махны биет хэмжээ буурсан ч үхэр, адууны махны боловсруулалт нэмэгдэж, боловсруулах салбарын 8-10 орчим хувийг бүрдүүлдэг мах боловсруулах, консервлох үйл ажиллагааны бодит үйлдвэрлэл (2024 оны суурьтай үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан дүн) өмнөх оны мөн үеэс 0.4 хувиар өслөө.



- Гурилын үйлдвэрлэлийн биет хэмжээ 2025 оны эхний 8 сард 102.9 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 9.9 хувиар өссөн байна.
- Гурилын үйлдвэрлэлийн биет хэмжээ нэмэгдсэн ч боловсруулах салбарын 5-7 орчим хувийг бүрдүүлдэг гурил болон цардуул, цардууллаг бүтээгдэхүүний үйлдвэрлэл бодит дүнгээр (2024 оны суурьтай үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан дүн) өмнөх оны мөн үеэс 1.2 хувиар буурлаа.



- Согтууруулах болон согтууруулах бус ундаа үйлдвэрлэлийн биет хэмжээ 2025 оны эхний 8 сард 374.0 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 6.6 хувиар буурлаа.
- Үйлдвэрлэлийн биет хэмжээ буурснаар боловсруулах салбарын 20-25 орчим хувийг бүрдүүлдэг ундааны бодит үйлдвэрлэл (2024 оны суурьтай үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан дүн) өмнөх оны мөн үеэс 0.2 хувиар буурлаа.




- Самнасан ноолуурын үйлдвэрлэл 2025 оны эхний 8 сард 815 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 79.7 хувиар өслөө.
- Ноолуурын үйлдвэрлэлийн биет хэмжээ нэмэгдсэн хэдий ч боловсруулах салбарын 3-5 орчим хувийг бүрдүүлдэг ээрэх, нэхэх, даавуу материал бэлтгэх бодит үйлдвэрлэл\* (2024 оны суурьтай үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан дүн) өмнөх оны мөн үеэс 18.6 хувиар буурсан байна.


\*Ноолууран сүлжмэл эдлэлийн биет хэмжээний бууралт голлон нөлөөлөв.




Барилгын салбарын үйлдвэрлэлийн голлох орц болох цемент, вакум цонх болон хаалганы үйлдвэрлэл нэмэгдэж, металл бэлдэц болон цувимлын үйлдвэрлэл бууралттай хэвээр байна.




■ Цемент үйлдвэрлэлийн биет хэмжээ 2025 оны эхний 8 сард 1,383 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 14.1 хувиар өссөн байна.



■ Катодын зэс үйлдвэрлэлийн биет хэмжээ 2025 оны эхний 8 сард 5.1 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 28.1 хувиар өслөө.




■ Металл бэлдэц болон цувимал бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээ 2025 оны эхний 8 сард 43.9 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 2.7 хувиар доогуур байна.




■ Вакум цонх, хаалганы үйлдвэрлэлийн биет хэмжээ 2025 оны эхний 8 сард 27.2 мянган м.кв болж, өмнөх оны мөн үеэс 18.5 хувиар өслөө.



Нүүрсний тээвэр сэргэснээр төмөр замын ачаа тээвэр эхний 8 сард өмнөх оны мөн түвшинд хүрэв. Инфляц өндөр түвшинд хадгалагдсанаар худалдаа, нийтийн хоолны салбарын бодит орлого буурсан бол зочид буудлын салбар аялал жуулчлалын улиралтай холбоотойгоор өссөн үзүүлэлттэй байна.



- Үйлчилгээний салбарын дийлэнхийг бөөний болон жижиглэн худалдааны салбар бүрдүүлдэг.
- Тус салбарын борлуулалтын орлого 2025 оны эхний 8 сард нэрлэсэн дүнгээр 38 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 0.1 хувиар өссөн бол үнийн нөлөөг засварласан бодит дүнгээр 0.3 хувиар буурсан байна. Хэдийгээр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад бодит борлуулалтын орлого буурсан боловч оны эхэн үетэй харьцуулахад өсөлтийн эрчим нэмэгдсэн байна.



- Зочид буудал болон нийтийн хоолны салбарын борлуулалтын орлого 2025 оны эхний 8 сард нэрлэсэн дүнгээр 22 хувь болон 11 хувиар тус тус өссөн байна.
- Харин инфляц эрчимжсэнээр үнийн нөлөөг засварласан зочид буудлын салбарын бодит орлогын дүн 4 хувиар өссөн бол нийтийн хоолны салбарын бодит орлогын дүн 5 хувиар буурсан байна.



- Төмөр замаар 2025 оны эхний 8 сард 29.5 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.5 хувийн өсөлттэй байна. Удаашралтай байсан нүүрс тээвэр сэргэснээр нийт төмөр замаар тээсэн ачаа өнгөрсөн оны мөн үеийн түвшинд ирэв.
- Агаараар тээвэрлэсэн ачаа өмнөх оны мөн үеэс 2.6 хувиар буурсан байна.
- Экспортын нүүрс тээврийн зай буурснаас үүдэн авто замаар 2025 оны эхний хагас жилд 40.8 сая тонн ачаа тээвэрлэж, өмнөх оны мөн үеэс 1.1 хувиар буурав




- 2025 оны эхний 8 сарын байдлаар Монгол Улсын хилээр орсон жуулчдын тоо 598 мянгад хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 17.7 хувиар өссөн байна. Наймдугаар сард 598 мянган жуулчин хүлээн авсан нь одоогоор түүхэн дээд хэмжээ юм.



2025 оны эхний 8 сарын байдлаар гадаад худалдааны бараа эргэлт 16.6 тэрбум ам.долларт хүрсэн бол худалдааны тэнцэл 1.7 тэрбум ам.долларын ашигтай гарлаа.


ЭКСПОРТ  
(сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Экспорт 2025 оны 8 дугаар сарын байдлаар 9,158 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 13 хувиар буурлаа.
- Нийт экспортын 95 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн бүрдүүлээ.


ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ  
ЭКСПОРТ (сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Нүүрсний экспортын орлого 3,4290 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 44 хувиар буурлаа.
- Зэсийн баямжалын экспортын орлого 3,444 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 75 хувиар өслөө.
- Алтны экспортын орлого 550 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 6 хувиар буурлаа.
- Төмрийн хүдрийн экспортын орлого 401 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 1 хувиар өслөө.

ИМПОРТ  
(сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- 2025 оны 8 дугаар сарын байдлаар импорт 7,477 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 0.3 хувиар буурсан байна.
- Нийт импортын 20 хувийг тоног төхөөрөмж, 17 хувийг нефтийн бүтээгдэхүүн, 11 хувийг суудлын автомашин эзэлж байна.
- Ачааны тээврийн хэрэгслийн импорт 26.6 хувиар, авто бензиний импорт 5.5 хувиар, дизель түлшний импорт 3.5 хувиар буурсан нь нийт импорт буурахад нөлөөллөө.

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ  
ИМПОРТ (сая ам.доллар)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар


- Нефтийн бүтээгдэхүүний импорт 1,242 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 4.2 хувиар буурлаа.
- Тоног төхөөрөмжийн импорт 1,465 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 5.2 хувиар өслөө.
- Суудлын автомашины импорт 806 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 17.8 хувиар өслөө.
- Барилгын материалын импорт 969 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 10.3 хувиар өслөө.
- Хүнсний импорт 780 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 6.2 хувиар өслөө.




2025 оны 8 дугаар сарын байдлаар уул уурхайн бүтээгдэхүүн нийт экспортын 95 хувийг бүрдүүллээ.




- Нүүрсний экспортын биет хэмжээ 2025 оны эхний 8 сард 52.9 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 4.4 хувиар буурлаа.



- Зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ 2025 оны эхний 8 сард 1,454 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 40.0 хувиар өслөө.




- Төмрийн хүдрийн экспортын биет хэмжээ 2025 оны эхний 8 сард 5,605 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 16.0 хувиар өслөө.




- Газрын тосны экспортын биет хэмжээ 2025 оны эхний 8 сард 2,386 мянган баррельд хүрч, өмнөх оны мөн үеэс 13.4 хувиар буурлаа.




2025 оны эхний 8 сард голлох хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүдийн экспорт өмнөх оны мөн үеэс буурлаа.




■ Малын махны экспорт 2025 оны эхний 8 сард 100 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 13 хувиар буурлаа.



■ Боловсруулсан арьс ширний экспорт 2025 оны эхний 8 сард 1 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 47 хувиар буурлаа.



■ Ноолуурын экспорт 2025 оны эхний 8 сард 149 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 51 хувиар буурлаа.



■ Ноосны экспорт 2025 оны эхний 8 сард 2.6 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 36 хувиар буурлаа.



ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ  
ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ХАНДЛАГА

НҮҮРС

(\$/тонн, Сингапурын бирж дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрс )



Эх сурвалж: Блүүмберг

- Сингапурын бирж (SGX) дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрсний 2025 оны 8 дугаар сарын дундаж үнэ 187 ам.долларт хүрч, өмнөх сараас 1 хувиар, өмнөх оны мөн үеэс 1 хувиар буурсан байна.

ЗЭС

(\$/тонн , Лондоны металлын бирж дэх цэвэр зэс)



Эх сурвалж: Блүүмберг

- Лондоны металлын бирж (LME) дэх цэвэр зэсийн үнэ 2025 оны 8 дугаар сарын дунджаар 9952 ам.доллар хүрч өмнөх оны мөн үеэс 7 хувиар өссөн байна.

ТӨМРИЙН БАЯЖМАЛ

(\$/тонн, Зүүнхойд Хятад дахь 62 хувийн агууламжтай төмрийн баяжмал)




Эх сурвалж: Блүүмберг

- Зүүн хойд Хятад дахь төмрийн баяжмалын 2025 оны 8 дугаар дундаж үнэ 104 ам.долларт хүрч, өмнөх сараас 3 хувиар, өмнөх оны мөн үеэс 11 хувиар өссөн байна.

ГАЗРЫН ТОС

(\$/баррель, Брент)



Эх сурвалж: Блүүмберг

- Брент газрын тосны 2025 оны 8 дугаар сарын дундаж үнэ 67 ам.долларт хүрч өмнөх сараас 1 хувиар буурсан хэдий ч өмнөх оны мөн үеэс 5 хувиар өслөө.



Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр 2025 оны эхний 8 сард 9.0 сая тонн нүүрс, 4.0 сая тонн төмрийн хүдэр болон баяжмал, 34.8 мянган тонн жоншны баяжмал, 27.2 мянган тонн зэсийн баяжмал арилжаалаад байна.



- 2025 оны 8 дугаар сарын байдлаар 2023 оноос хойш нийт 46.3 сая тонн нүүрс арилжиж, 5.2 тэрбум ам.долларын орлого олжээ.
- Үүнээс 2024 онд 22.4 сая тонн нүүрс арилжиж, 2.4 тэрбум ам.долларын орлого олжээ.
- Харин 2025 оны эхний 8 сард 9.0 сая тонн нүүрс борлууллаа.



- 2025 оны 8 дугаар сард нүүрсний дуудах дундаж үнэ 70 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 74 ам.доллар байв.
- Нүүрсний төрлөөс хамааран 8 дугаар сард хэлцлийн доод үнэ 20 ам.доллар, дээд үнэ 140 ам.долларт хүрэв.




- 2025 оны 8 дугаар сарын байдлаар 2023 оны 9 дүгээр сараас хойш нийт 7.1 сая тонн төмрийн хүдэр арилжиж, 471 сая ам.долларын орлого олжээ
- Үүнээс 2024 онд 2.4 сая тонн төмрийг арилжаалж, 167 сая ам.долларын орлого олжээ.
- Харин 2025 оны эхний 8 сард 4.0 сая тонн төмрийн хүдэр борлууллаа.



- Төмрийн хүдэр болон баяжмалын 8 дугаар сарын дуудах дундаж үнэ 63 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 65 ам.доллар ам.доллар байв.
- Төмрийн төрлөөс хамааран 8 дугаар сард хэлцлийн доод үнэ 55 ам.доллар, дээд үнэ 85 ам.долларт хүрэв.

Төлбөрийн тэнцэл 2025 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар 5 сая ам.долларын ашигтай гарлаа. Гадаад валютын улсын нөөц 2025 оны 8 дугаар сарын эцэст өмнөх сараас 304 сая ам.доллараар нэмэгдэж, 5,683 сая ам.долларт хүрлээ.



- Төлбөрийн тэнцэл 2025 оны 8 дугаар сарын байдлаар 5 сая ам.долларын алдагдалтай байна.
  - Өмнөх оны мөн үетэй харьцуулахад урсгал дансны алдагдал 619 сая ам.доллараар, санхүүгийн дансны ашиг 1,080 сая ам.доллараар тус тус их байна.
- Гадаад валютын улсын нөөц 2025 оны 8 дугаар сарын эцэст 5,683 сая ам.доллар болж, өмнөх сараас 304 сая ам.доллараар, өмнөх оны мөн үеэс 979 сая ам.доллараар тус тус өслөө.
- Төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2025 оны 8 дугаар сард өдөрт дунджаар 0.3 төгрөгөөр суларч, сарын эцэст 3,593 төгрөгт хүрлээ.
- Төв банк 2025 оны 8 дугаар сард нийт 375 сая ам.долларыг зах зээлд нийлүүллээ.
  - Төв банк 2025 оны эхний 8 сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 55 сая ам.доллараар их 4.2 тэрбум ам.долларыг дуудлага худалдаагаар зах зээлд нийлүүлээд байна.


\*Нийт хөрөнгө оруулалтаас хөрөнгө оруулалтын буцаалт болон эзэлийн эргэн төлөлттэй холбоотой гарах урсгалыг хассан дүн




Инфляц 2025 оны 8 дугаар сард 8.8 хувьд хүрч, өмнөх сараас 0.7 нэгж хувиар өслөө. Инфляц өмнөх сараас 0.7 нэгж хувиар өсөхөд мах болон хүнсний ногооны үнийн өсөлт голлон нөлөөлсөн байна. Нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 1.6 хувиар өслөө.




- Инфляц 2025 оны 8 дугаар сард улсын хэмжээнд 8.8 хувь гарлаа.
- Импортын гаралтай инфляц нийт инфляцын 2.3 нэгж хувь (25.6 хувь)-ийг бүрдүүлж байна.
- Дотоодын бараа, үйлчилгээний үнийн өсөлт нийт инфляцын 6.5 нэгж хувь буюу 74.4 хувийг эзэлж байна.



- 2025 оны 8 дугаар сард нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 1.6 хувиар өслөө.
- Сарын инфляц 1.6 хувь гарахад боловсролын үйлчилгээ 12.8 хувиар, тээврийн бүлэг 1.5 хувиар, хүнс 0.8 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.



- Суурь инфляц нь нийт инфляцаас хүнс, шатахуун, хатуу түлшний үнийг хасаж тооцсон эрэлтийн гаралтай инфляц юм.
- 2025 оны 8 дугаар сард суурь инфляц 7.9 хувь гарч, нийт инфляцын 4.9 нэгж хувийг бүрдүүлж байна.
- Суурь инфляц сүүлийн 5 сар дараалан буурсан үзүүлэлттэй байна.



- Мах, сүү, гурил зэрэг голлох бүтээгдэхүүнүүдийн үнийн өсөлт саарч, жилийн инфляцын 7.5 хувийг бүрдүүллээ.
- Гурил, гурилан бүтээгдэхүүний үнэ өмнөх оны мөн үеэс 0.7 хувиар өслөө.
- Сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний үнэ өмнөх оны мөн үеэс 2.2 хувиар өслөө.
- Хонины махны үнэ өмнөх оны мөн үеэс 14.1 хувиар өслөө.




Олон улсад чингэлэг тээврийн үнэ 1,913 сая ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 52 хувиар буурлаа. Хүнсний үнийн индекс 2025 оны 8 дугаар сард өмнөх оны мөн үеэс 6.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



- Хүнсний инфляц 2025 оны 8 дугаар сард 9.9 хувь болж, нийт инфляцын 2.7 нэгж хувийг бүрдүүлэв. Хүнсний инфляц өмнөх сараас эрчимжихэд мах болон хүнсний ногооны үнийн өсөлт нөлөөллөө.
- Хүнсний бус инфляц 8.4 хувь болж, нийт инфляцын 6.1 нэгж хувийг бүрдүүллээ.



- Төгрөгийн амдоллартой харьцах ханш 2025 оны 8 дугаар сард дунджаар 3,592 төгрөг болж, өмнөх сараас 0.2 хувиар суларлаа.
- Импортын бараа бүтээгдэхүүний үнэ 2024 оны 8 дугаар сард өмнөх сараас 0.9 хувиар өслөө.



- АНУ-ын тарифын бодлогоос үүдэлтэйгээр дэлхийн чингэлэг тээврийн үнэ өсөөд байсан бол 6 дугаар сараас эхлэн аажмаар буурч эхэллээ.
- Чингэлэг тээврийн үнэ (Drewry World Container Index) 2025 оны 9 дүгээр сарын 18-ний өдрийн байдлаар 40 фут контейнер тутамд 1,913 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 52 хувиар буурсан байна.
- Чингэлэг тээврийн үнэ буурч байгаа нь нийлүүлэлтийн шалтгаантай инфляцын дарамтыг бууруулж байна.




- НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас зарладаг дэлхийн хүнсний үнийн индекс хүнсний барааны 5 бүлгийн дундаж үнийн сар бүрийн өөрчлөлтийг харуулдаг.
- Хүнсний үнийн индекс 2025 оны 8 дугаар сард 130.1 болж, өмнөх оны мөн үеэс 6.9 хувиар өссөн байна.
- Сүүлийн сар дэлхийн зах зээл дээр мах, ургамлын тос, элсэн чихрийн үнэ өссөн бол сүүн бүтээгдэхүүн болон үр тарианы үнэ буурсан байна.



Нүүрсний үнийн уналтаас шалтгаалан төсвийн нийт орлого 2025 оны 8 дугаар сарын байдлаар 19.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 0.6 их наяд төгрөг буюу 2.9 хувиар буураад байна.


ТӨСВИЙН ОРЛОГО  
(орлогын эх үүсвэрээр, их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

- Төсвийн нийт орлого 19.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 0.6 их наяд төгрөг буюу 2.9 хувиар буурсан байна.
- Төсвийн орлогын бууралтад нийт АМНАТ-ийн орлого 1.0 их наяд төгрөгөөр буюу өмнөх оноос 29.2 хувиар, ААНОАТ 1.0 их наяд төгрөг буюу 21.6 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.

ТӨСВИЙН ЗАРЛАГА  
(зарлагын ангиллаар, их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

- Төсвийн зарлага 2025 оны 8 дугаар сарын байдлаар 19.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.0 их наяд төгрөг буюу 11.6 хувиар нэмэгдсэн байна.
- Төрийн албан хаагчдын цалин хөлс болон тэтгэвэр, тэтгэмжийг 2025.01.01-ний өдрөөс өмнөх оны инфляцын түвшинд уялдуулан 6.0 хувиар нэмэгдүүлсэн.
- Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 4.1 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 25.0 хувиар, тэтгэвэр, тэтгэмж 3.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 17.2 хувиар тус тус өссөн байна.

ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ  
(их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2025 оны 8 дугаар сарын байдлаар 1.2 их наяд төгрөгийн алдагдалтай гарлаа.
- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалтай гарахад нүүрсний үнийн бууралттай холбоотойгоор АМНАТ болон ААНОАТ-ын орлого багассан нь төсвийн орлого төвлөрүүлэлт саарахад голлох нөлөө үзүүлээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)  
(Зүүн тэнхлэг: их наяд төгрөг, Баруун тэнхлэг: ДНБ-д эзлэх хувь)




Эх сурвалж: Сангийн яам

- Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл 2025 оны хоёрдугаар улиралд 35.5 их наяд төгрөг буюу ДНБ-д эзлэх хувь 39.5 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 17.5 хувиар өссөн байна.
- Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа хуульд заасан тусгай шаардлагыг хангаж байна.



Мөнгөний нийлүүлэлт 2025 оны 8 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 6.5 хувиар өсөж, 44.3 их наяд төгрөгт хүрлээ. Банкны салбарын зээлийн үлдэгдэл 2025 оны 8 дугаар сард 42.3 их наяд төгрөгт хүрч, жилийн өсөлт 23.6 хувьд хүрлээ.



- Мөнгөний нийлүүлэлт 2025 оны 8 дугаар сарын эцэст 44.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 6.5 хувиар өсөж, өсөлтийн хурд өмнөх сараас эрчимжлээ.
- Төгрөгийн хадгаламж нийт өсөлтийн 6.8 нэгж хувь, төгрөгийн харилцах 1.6 нэгж хувь, гадаад валютын хадгаламж 2.2 нэгж хувь, гадаад валютын харилцах -4.1 нэгж хувийг тус тус бүрдүүлсэн байна.



- Нийт хадгаламж 28.5 их наяд төгрөгт хүрч хүрч, өмнөх оны мөн үеэс 15.1 хувиар өслөө.
- Төгрөгийн хадгаламж 23.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 13.9 хувиар, өмнөх сараас 0.1 хувиар тус тус өслөө.
- Гадаад валютын хадгаламж 5.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 20.5 хувиар өслөө.



- Банкнудын зээлийн үлдэгдэл 2025 оны 8 дугаар сарын эцэст 42.3 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 23.6 хувиар өслөө.
- Нийт зээлийн үлдэгдэлд эзлэх чанаргүй зээлийн хувь хэмжээ 5.2 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.6 нэгж хувиар буурсан байна.



- Банкнудын шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 2025 оны 8 дугаар сард 17.0 хувь болж, өмнөх сараас 0.1 нэгж хувиар буурсан байна.
- Банкнудын шинээр татсан хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 2025 оны 8 дугаар сард 11.7 хувь болж, өмнөх сараас 0.3 нэгж хувиар өслөө.



Хөдөө аж ахуйн салбарын өсөлт тогтворжиж, нийт ажилчдын тоо 1 сая 390 мянгад хүрсэн ч, ажилгүй иргэдийн тоо буурснаар ажиллах хүчний оролцооны түвшин 61.9 хувь болж буурлаа.



Сүүлийн 3 улирал дараалан буурсан өрхийн бодит орлогын өсөлт сэргэж 8.0 хувиар өслөө.

ӨРХИЙН БОДИТ ОРЛОГЫН ӨСӨЛТ  
(хувь)

■ Бусад орлого  
■ ХАА-н орлого  
■ Тэтгэвэр, тэтгэмж  
■ Цалин хөлс  
■ Өрхийн бодит орлого

8.0  
17.3  
1.9

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ӨРХИЙН НЭРЛЭСЭН ОРЛОГО, ЗАРЛАГА  
БОЛОН ХАДГАЛАМЖИЙН ӨСӨЛТ  
(хувь)

орлого  
зарлага  
хадгаламж

8.0  
16.9  
4.8

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ӨРХИЙН ДУНДАЖ НЭРЛЭСЭН ОРЛОГО  
(сая төгрөг)

1.6 саяас бага  
1.6 саяас их

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ӨРХИЙН БОДИТ ОРЛОГЫН ӨСӨЛТ  
(хувь)

■ Улаанбаатар  
■ Сумын төв  
■ Хөдөө

11.8  
6.3  
10.0

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

■ Өрхийн бодит орлого 2025 оны 2 дугаар улирлын байдлаар 8.0 хувиар өслөө.

■ Бодит орлогын өсөлтөд иргэдийн цалингийн орлого өмнөх оны мөн үеэс нэрлэсэн дүнгээр 264.4 мянган төгрөгөөр, тэтгэвэр, тэтгэмжийн орлого 55.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлөв.

■ 2024 оны 2 дугаар улирлаас эрчимтэй нэмэгдсэн цалингийн орлого нийт орлогын 54.0 хувийг бүрдүүлэв.

■ Өрхийн орлогын өсөлт зарлагын өсөлтөөсөө давж эхлээд байгаа ч, хадгаламжийн өсөлт энэ онд буурч байна.

■ Бага орлоготой өрхийн орлого төдийлөн өсөлтгүй хэвээр байна.

■ Нийт өрхийн 30.8 хувийг бүрдүүлж буй 1.6 сая төгрөгөөс бага орлоготой өрхүүдийн сарын дундаж орлого нэрлэсэн үнээр 994 мянган төгрөг буюу өмнөх улирлаас 5.6 мянган төгрөгөөр өссөн бол 1.6 сая төгрөгөөс дээш орлоготой өрхүүдийн сарын дундаж орлого 3.2 сая төгрөг болж, өмнөх улирлынхаас 229 мянган төгрөгөөр буурсан байна.

■ Хөдөө, сумын төвийн өрхийн бодит орлого Улаанбаатар болон улсын дундажаас өндрөөр өсөв.

■ Үүнд 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хөдөө суманд ажиллаж байгаа төрийн албан хаагчдын орон нутгийн нэмэгдлийг үндсэн цалингийн 40 хувиар тооцож нэмэгдүүлсэн нь голлон нөлөөлжээ.



Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт ААН-ийн тоо 2025 оны 2 дугаар улиралд 270.9 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 25.2 мянгаар буюу 10.3 хувиар нэмэгдлээ.

НИЙТ БҮРТГЭЛТЭЙ ААН-ИЙН ТОО  
(мянга, үйл ажиллагаа эрхлэлтээр)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт ААН-ийн тоо 2025 оны 2 дугаар улиралд 270.9 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 25.2 мянгаар буюу 10.3 хувиар нэмэгдлээ.
- Уг өсөлтийн 17.2 мянгыг үйл ажиллагаа эхлээгүй буюу шинээр байгуулагдсан ААН-үүд бүрдүүлсэн бол 8.6 мянгыг үйл ажиллагаа явуулж буй ААН-үүд бүрдүүллээ.
- Үйл ажиллагаа явуулж буй болон шинээр байгуулагдсан ААН-ийн тоо нэмэгдэж байгаа нь бизнесийн үйл ажиллагаа идэвхжиж байгааг илтгэж байна.


ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААН-ИЙН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ  
(ААН-ийн тоо, салбараар)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Дотоодын эдийн засаг идэвхжиж, худалдан авах чадвар сайжирснаар худалдаа, боловсруулах салбарт үйл ажиллагаа явуулж буй ААН 3.4 мянгаар нэмэгдлээ.
- Мөн хөдөө аж ахуйг дэмжих бодлого хэрэгжүүлсэн зэрэгтэй холбоотойгоор тус салбарын үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо 41 хувиар өссөн байна.


ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААН-ИЙН ТОО  
(мянга, ажиллагчдын тоогоор)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Үйл ажиллагаа явуулж буй 111.7 мянган ААН-ийн 96.7 мянга нь бичил буюу 1-9 ажилтантай ААН-үүд байна.
- Мөн 1-9 ажилтантай ААН-үүд үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн өсөлтийн 93 хувийг бүрдүүлж байна.

ХЭРЭГЛЭГЧИЙН ИТГЭЛИЙН ИНДЕКС  
(улирлаар, 2018=100)




Эх сурвалж: Үндэсний судалгаа зөвлөгөөний төв (Эн-Ар-Си-Си ХХК)

- Хэрэглэгчийн итгэлийн индекс (ХИИ) 2025 оны 2 дугаар улиралд 98.9-д хүрч өмнөх оны мөн үеэс 9.8 нэгжээр муудлаа.
- ХИИ-ийг задлан харвал хэрэглэгчдийн эдийн засгийн одоогийн нөхцөлийн үнэлэмжийг харуулдаг Өнөөгийн байдлын индекс өмнөх оны мөн үеэс 8.3 нэгжээр нэмэгдсэн. Үүнд хэрэглэгчдийн ажлын олдцын үнэлэмж сайжирсан нь нөлөөллөө.
- Харин эдийн засгийн ирэх 6 сарын хүлээлтийг харуулдаг Ирээдүйн хүлээлтийн индекс 15.7 нэгжээр буурсан бөгөөд үүнд бизнесийн нөхцөл, ажлын олдоц, орлогын хүлээлт муудсан нь нөлөөллөө.




ОХУ-ын эдийн засаг 2025 оны 2 дугаар улиралд 1.1 хувиар өслөө. Инфляцын түвшин 2025 оны 8 дугаар сард 8.1 хувьд хүрч, өмнөх сараас 0.7 нэгж хувиар буурлаа.

**БОДИТ ДНБ-ИЙ ӨСӨЛТ**  
(хувь)




■ ОХУ-ын эдийн засгийн өсөлт 2025 оны 2 дугаар улиралд 1.1 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 3.2 нэгж хувиар буурлаа.

**ЭКСПОРТ, ИМПОРТЫН ӨСӨЛТ**  
(хувь, тухайн сар)




- 2025 оны 7 дугаар сарын байдлаар экспорт 38.0 тэрбум ам.доллар, импорт 24.9 тэрбум ам.долларт хүрч, худалдааны тэнцэл 13.2 тэрбум ам.долларын ашигтай байна.
- Экспорт 2025 оны 7 дугаар сард өмнөх оны мөн үеэс 6.7 хувиар өслөө.
- Импорт 2025 оны 7 дугаар сард өмнөх оны мөн үеэс 2.5 хувиар буурлаа.

**ИНФЛЯЦ**  
(хувь)



- ОХУ-ын инфляц зорилтот түвшин болох 4 хувиас өндөр хэвээр байна.
- Инфляцын түвшин 2025 оны 8 дугаар сард 8.1 хувь болж, өмнөх сараас 0.7 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 1.0 нэгж хувиар буурсан байна.
- ОХУ-ын төв банкнаас 7 дугаар сарын 25-ны өдөр бодлогын хүүг 2 нэгж хувиар бууруулж, 18 хувьд хүргэх шийдвэр гаргасан.

**ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖЕРИЙН ИНДЕКС (PMI)**  
(нэгж, хувь)



- Аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерүүдийн индекс (PMI) 2025 оны 8 дугаар сард 48.7 болж, өмнөх сараас 1.7 нэгжээр өслөө.
- Аж үйлдвэрлэлийн бодит өсөлт 2025 оны 7 дугаар сарын байдлаар 0.7 хувь болж, өмнөх сараас 1.3 нэгж хувиар буурлаа.



Хэдийгээр дотоод эрэлт сул хэвээр байгаа ч экспорт, хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр БНХАУ-ын эдийн засаг 2025 оны 2 дугаар улиралд 5.2 хувиар өслөө.




- БНХАУ-ын эдийн засаг 2025 оны 2 дугаар улиралд 5.2 хувиар өслөө.
- Экспортын өсөлт 2025 оны 8 дугаар сард 4.4 хувь, импорт 2025 оны 8 дугаар сард 1.3 хувиар өсөж өмнөх сараас суларсан үзүүлэлттэй байна.

Тэмдэглэл: Оны эхний 2 сарын статистик нэгтгэгдэн зарлагдаг.




- Аж үйлдвэрийн гарц 2025 оны 8 дугаар сард 5.2 хувиар өссөн нь өнгөрсөн оны 11 дүгээр сараас хойших хамгийн сул өсөлт болж, эдийн засагчдын хүлээлтээс бага гарлаа.
- Хэрэглээний төлөвийг илэрхийлэх жижиглэн худалдааны борлуулалт 2025 оны 8 дугаар сард 3.4 хувь болж саарсан байна.

Тэмдэглэл: Оны эхний 2 сарын статистик нэгтгэгдэн зарлагдаг.



- Хэрэглээний үнийн индекс 2025 оны 8 дугаар сард -0.4 хувь буюу дефляцитай гарлаа.
- Үйлдвэрлэгчийн үнийн индексийн өөрчлөлт 2025 оны 8 дугаар сард -2.9 хувь гарч, үнийн уналт өмнөх сараас саарлаа.



- Аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерийн индекс 2025 оны 8 дугаар сард 49.4 болж, агшилтыг илэрхийлсэн хэвээр байна.
- Аж үйлдвэрийн бус салбарын болон нэгдсэн худалдан авалтын менежерийн индексүүд өмнөх сараас өсөж тэлэлтийг илэрхийлэх 50-аас дээш түвшинд хадгалагдаж байна.

Тэмдэглэл: Тус индекс нь богино хугацааны идэвхжиллийг илэрхийлэх бөгөөд ААН-үүдийн худалдан авалт, үйлдвэрлэл, ажил эрхлэлт, түүний эдийн нөөц зэрэг үзүүлэлтийн талаарх аж үйлдвэрийн салбарын 3200 судалгаа, аж үйлдвэрийн бус салбарын 4300 судалгаанд үндэслэн сар бүр тооцдог. Индексийн 50-аас дээш утга нь тэлэлтийг, 50-аас доош нь агшилтыг илэрхийлнэ.